

**ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2025 оны 10 дугаар сарын 16-ны өдөр, Пүрэв гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

Хуралдааны товч тэмдэглэл: 1-2

Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл: 3-12

1.Монгол Улсын Ерөнхий сайдыг огцруулах санал /үргэлжлэв/ 3-12

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганы
Төрийн байгуулалтын байнгын хорооны
10 дугаар сарын 16-ны өдөр /Пүрэв гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Ц.Сандаг-Очир ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 32 гишүүнээс 19 гишүүн хүрэлцэн ирж, 59.4 хувийн ирцтэйгээр хуралдаан 9 цаг 32 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: О.Алтангэрэл, Б.Батбаатар, Ө.Шижир;
Чөлөөтэй: Ж.Баярмаа, Т.Доржханд, О.Цогтгэрэл, Л.Энх-Амгалан,
Д.Энхтуяа;
Эмнэлгийн чөлөөтэй: А.Ганбаатар, Б.Пүрэвдорж.

Нэг.Монгол Улсын Ерөнхий сайдыг огцруулах санал /үргэлжлэв/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын Ерөнхий сайд Г.Занданшатар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын дарга Ч.Дондогмаа, мөн газрын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Хишигсүрэн, Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны зөвлөх Ц.Баянмөнх, Ч.Батбаямба, референт А.Амармэнд, Б.Баясах, О.Мөнгөнчавхдас нар байлцав.

Хуралдаан Улсын Их Хурлын гишүүдийн үгээр үргэлжлэв.

Улсын Их Хурлын гишүүн Б.Жавхлан, Б.Хэрлэн, С.Бямбацогт, М.Энхцэцэг, М.Мандхай, Д.Батлут, Э.Болормаа нар үг хэлэв.

Ц.Сандаг-Очир: Монгол Улсын Ерөнхий сайд Гомбожавын Занданшатарыг огцруулах саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 3
Татгалзсан: 19
Бүгд: 22
13.6 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 10 цаг 10 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 38 минут үргэлжилж, ирвэл зохих 32 гишүүнээс 22 гишүүн хүрэлцэн ирж, 68.8 хувийн ирцтэйгээр 10 цаг 10 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Ц.САНДАГ-ОЧИР

Тэмдэглэл хөтөлсөн:

ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 10 дугаар сарын 16-ны өдөр,
Пүрэв гараг
Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар” танхим
9 цаг 32 минут.

ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Ц.Сандаг-Очир: Эрхэм гишүүдээ, Төрийн байгуулалтын байнгын хороо 2025 оны 10 сарын 16-ны өглөөний 9 цагаас товлогдсон байгаа. Одоо 9 цаг 19 минут болж байна. Ирвэл зохих 32 гишүүнээс 12 гишүүн одоогоор ирээд байна. Хуралдааны ирц 37,5 хувьтай байна. Тийм учраас гишүүдийг цагаа барьж, хуралдаандаа ирэхийг урьж байна. Бид хуралдаан хойшлуулах хуулийн хугацаа байхгүй. Одоогийн байдлаар ирсэн гишүүдийг танилцуулъя. Аюушийн Ариунзаяа гишүүн 9 цаг 9 минутад ирсэн байна, Жадамбын Бат-Эрдэнэ гишүүн 9 цаг 12 минутад ирсэн байна, Баярмагнайн Баярбаатар гишүүн 9 цаг 9 минутад бүртгүүлсэн байна, Энхбатын Болормаа гишүүн ирсэн байна, Цэрэнпилийн Даваасүрэн гишүүн ирсэн байна, Сархадын Зулпхар гишүүн ирсэн байна, Цагаанхүүгийн Идэрбат гишүүн ирсэн байна, Лхагвын Мөнхбаатар гишүүн ирсэн байна, Чинбатын Номин гишүүн ирсэн байна, Лувсаннамсрайн Оюун-Эрдэнэ гишүүн ирсэн байна, Цэндийн Сандаг-Очир ирсэн байна, Отгоны Саранчулуун гишүүн ирсэн байна. Одоогийн байдлаар эдгээр 12 гишүүн ирээд байна. Бусад 20 гишүүн ирээгүй байна, дуудаарай ажлын албанаас гишүүдээ.

10 цагаас чуулганы нэгдсэн хуралдаан хуваарийн дагуу хуралдах ёстой. Манай хуралдаан ер нь бол удахгүй, ирц шинээр эхэлнэ, 10 хүн үг хэлнэ. Тооцохоор дунджаар нэг цаг орчим болох төлөвтэй байгаа. Тийм учраас хурлаа цагт нь яаралтай явуулах хэрэгтэй байна. Хэрлэн гишүүн орж ирж байна. Гишүүд ирцдээ ороорой сүүлд ирсэн гишүүд. Лувсаннъямын Гантөмөр гишүүн ирцдээ орсон байна, Гончигдоржийн Уянгахишиг гишүүн ирцдээ орсон байна, Чулуунбилэгийн Лодойсамбуу гишүүн ирцдээ орсон байна. Одоогоор 15 гишүүн ирж, хуралдааны ирц 46,9 хувьтай байна. 9 цаг 26 минут болж байна. 9 цагаас товлогдсон хурал, 10 цагаас нэгдсэн чуулгантай гишүүдээ. Хуралдаандаа ирээрэй.

Хуралдааны ирц 17 гишүүн ирснээр 53,1 хувийн ирцтэй болсон байна. Ирц шинээр үүсэж байгаа. 5 дахь өдөр, 1 дэх өдөр хуралдаан хаасан учраас өнөөдөр ирцийг шинээр эхлүүлсэн. Хуралдаан хэлэлцэх асуудал үргэлжилж байгаа учраас үг хэлэх гишүүд асуулт асууж, хариулт авч дууссан. Одоо үг хэлэх гишүүд өмнөх хуралдаан дээр 10 хүн үлдсэн байгаа. Энэ 10 хүн яг дарааллаараа үгээ хэлээд явна. Үг хэлэх гишүүдийн хамгийн эхэнд Жавхлан сайд үг хэлэхээр байгаа. Жавхлан сайд хуралдаа ирээгүй байна.

Хуралдааны ирцийг танилцуулъя. Аюушийн Ариунзаяа гишүүн ирсэн байна, Жадамбын Бат-Эрдэнэ гишүүн ирсэн байна, Баярмагнайн Баярбаатар гишүүн ирсэн, Энхбатын Болормаа гишүүн ирсэн, Сандагийн Бямбацогт гишүүн ирсэн, Лувсаннъямын Гантөмөр гишүүн ирсэн, Цэрэнпилийн Даваасүрэн гишүүн ирсэн, Сархадын Зулпхар гишүүн ирсэн, Цагаанхүүгийн Идэрбат гишүүн ирсэн, Чулуунбилэгийн Лодойсамбуу гишүүн ирсэн, Лхагвын Мөнхбаатар гишүүн ирсэн,

Чинбатын Номин гишүүн ирсэн, Лувсаннамсрайн Оюун-Эрдэнэ гишүүн ирсэн, Цэндийн Сандаг-Очир ирсэн, Отгоны Саранчулуун гишүүн ирсэн, Гончигдоржийн Уянгахишиг гишүүн ирсэн, Бадарчийн Хэрлэн гишүүн ирсэн байна. Ингээд нийтдээ 17 гишүүн ирсэн байна.

Ирээгүй гишүүдийг нэг танилцуулаадахъя бас. Оюунсайханы Алтангэрэл гишүүн гадаад томилолттой, Дашзэвгийн Амарбаясгалан гишүүн, Мягмарсүрэнгийн Бадамсүрэн гишүүн, Жудагийн Баярмаа гишүүн, Амгаланбаатарын Ганбаатар гишүүн, Тогмидын Доржханд гишүүн, Нямтайширын Номтойбаяр гишүүн, Эрдэнэбилэгийн Одбаяр гишүүн, Бөхчулууны Пүрэвдорж гишүүн, Цэвэгдоржийн Туваан гишүүн, Одонгийн Цогтгэрэл гишүүн, Өлзийхүүгийн Шижир гишүүн, Лувсанцэрэнгийн Энх-Амгалан гишүүн, Доржзовдын Энхтуяа гишүүд хуралдаа ирэхийг урьж байна.

Улсын Их Хурлын гишүүддээ энэ өглөөний мэндийг хүргэе. Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирсэн тул Төрийн байгуулалтын байнгын хорооны 2025 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.8 дахь хэсэгт заасны дагуу хуралдааны ирцийг танилцуулъя. 7.8-д хуралдаан даргалагч хуралдааны ирцийг гишүүний сонгогдсон тойрог, нэрээр дараах дарааллаар нь танилцуулна заасан байна. Тийм учраас хуралдааны ирцийг танилцуулъя. Аюушийн Ариунзаяа гишүүн ирсэн байна, Жадамбын Бат-Эрдэнэ гишүүн 4 дүгээр тойргоос сонгогдсон хүрэлцэн ирсэн байна, Баярмагнайн Баярбаатар гишүүн 8 дугаар, жагсаалтаар сонгогдсон хүрэлцэн ирсэн байна, Энхбатын Болормаа гишүүн жагсаалтаар сонгогдсон хуралдаа ирсэн байна, Сандагийн Бямбацогт гишүүн 2 дугаар тойрог, Болормаа гишүүн 2 дугаар тойрог юм байна шүү, тийм, андуурсан байна уучлаарай. Сандагийн Бямбацогт гишүүн 2 дугаар тойрог хуралдаандаа ирсэн, Лувсаннъямын Гантөмөр гишүүн жагсаалтаар сонгогдсон хуралдаа ирсэн, Цэрэнпилийн Даваасүрэн гишүүн 4 дүгээр тойргоос сонгогдсон чуулганы хуралдаа ирсэн байна, Сархадын Зулпхар гишүүн жагсаалтаар сонгогдсон хуралдаа ирсэн байна, Цагаанхүүгийн Идэрбат гишүүн 6 дугаар тойргоос сонгогдсон хуралдаа ирсэн байна, Чулуунбилэгийн Лодойсамбуу гишүүн 12 дугаар тойргоос сонгогдсон хуралдаа ирсэн байна, Лхагвын Мөнхбаатар гишүүн 4 дүгээр тойргоос сонгогдсон хуралдаа ирсэн, Чинбатын Номин гишүүн 11 дүгээр тойргоос сонгогдсон хуралдаа ирсэн, Лувсаннамсрайн Оюун-Эрдэнэ гишүүн 6 дугаар тойргоос сонгогдсон хуралдаа ирсэн, Цэндийн Сандаг-Очир 13 дугаар тойргоос сонгогдсон хуралдаа ирсэн, Отгоны Саранчулуун гишүүн жагсаалтаар сонгогдсон хуралдаа ирсэн, Цэвэгдоржийн Туваан гишүүн 5 дугаар тойргоос сонгогдсон хуралдаа ирсэн, Гончигдоржийн Уянгахишиг гишүүн жагсаалтаар сонгогдсон хуралдаа ирсэн байна, Бадарчийн Хэрлэн гишүүн жагсаалтаар сонгогдсон хуралдаа ирсэн байна гэх мэт. Амарбаясгалан дарга орж ирсэн байна, 2 дугаар тойргоос сонгогдсон. Ингээд нийтдээ хуралдааны ирц 19 гишүүн ирж, 59,4 хувиар ирсэн байна.

Албан ёсоор чөлөөтэй улсуудыг Оюунсайханы Алтангэрэл гишүүн гадаадад томилолттой, Батын Батбаатар гишүүн гадаадад томилолттой, Нямтайширын Номтойбаяр гадаадад томилолттой юу, ирсэн үү? Ирж байгаа юм байна. Өлзийхүүгийн Шижир гишүүн ирчихсэн үү, хаана байна вэ? Шижир гишүүн гадаадад томилолттой байгаа юм байна шүү. Ийм гишүүд, Амгаланбаатарын Ганбаатар гишүүн өвчтэй, Бөхчулууны Пүрэвдорж гишүүн өвчтэй гэж Ажлын албанд албан

ёсоор тэмдэглүүлсэн байна. Бусад гишүүд хүндэтгэн үзэх шалтгаангүй бол хуралдаа ирэхийг хүсэж байна. Ирцийг танилцуулж дууслаа.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. Хэлэлцэх асуудал 1.Монгол Улсын Ерөнхий сайдыг огцруулах санал Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг нарын 54 гишүүнээс 2025 оны 10 сарын 07-ны өдөр Улсын Их Хуралд албан ёсоор тавьсан хэлэлцэх асуудлыг үргэлжлүүлнэ. Хэлэлцэх асуудалдаа оръё.

Монгол Улсын Ерөнхий сайдыг огцруулах саналыг хэлэлцэнэ. Уг асуудлыг Төрийн байгуулалтын байнгын хорооны 2025 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэж эхэлсэн бөгөөд гишүүд асуулт асууж, дууссан. 6 гишүүн үг хэлсэн. Гишүүдийн, гишүүд нэрсийн дарааллаар үргэлжлүүлэн үг хэлнэ. Дэлгэц дээр үргэлжлүүлж үг хэлэх гишүүдийн нэрс байна. Ерөнхий сайдыг огцруулах саналтай холбогдуулан үг хэлэх гишүүд үгээ хэлж эхэлнэ. Болдын Жавхлан гишүүнээр эхэлнэ. Болдын Жавхлан гишүүний микрофоныг өгье. Ажлын хэсгийн 6 номерын микрофон.

Б.Жавхлан: Байнгын хороон дарга, эрхэм гишүүдийн өглөөний мэндийг эрье. Би нэг их олон зүйл ярихгүй. 1990 онд Монгол Улс парламентын засаглалтай болсноос хойш 35 жил болж байна. Энэ хугацаанд Улсын Их Хурлын дарга Гомбожавын Занданшатар Улсын Их Хурлын даргын индэр дээрээс байгуулсан засгийн газраа хамгийн их хамгаалж, хамгийн урт тогтвортой ажиллуулсан байдаг юм. Өмнөх Засгийн газар 1990 оноос хойш хамгийн урт ажилласан Засгийн газар. Яагаад гэвэл өнөөдрийн Ерөнхий сайд тухайн үеийн Улсын Их Хурлын дарга маань энэ Засгийн газрыг машинд их дэмжиж, маш их хамгаалж, бүр Үндсэн хуулийн тогтолцоонд хүртэл энэ өөрчлөлтүүдийг хийсэн байдаг юм.

Гэтэл өнөөдөр тэр Засгийн газарт нь ажиллаж байсан эрхэм сайдууд маань оройлон энэ хүнийг өнөөдөр Ерөнхий сайдаар бүгдээрээ намын хамт олон олонхоороо дэмжиж байгуулсан Засгийн газрыг нь 100 дахь хоног дээр нь огцруулах гээд бүгдээрээ энэ хүнийг ганцааранг нь буланд шахаад, өнөөдрийн Байнгын хороог хуралдацгааж байна. Өнөөдөр Засгийн газрыг огцруулах гээд ч юм уу, эсвэл нэг сандал ширээний асуудал яригдаж байгаа мэт боловч энэ урт түүхэндээ Монгол төрийн эмгэнэлт түүх болон үлдэнэ дээ. Би дахиад хэлье Засгийн газрын дундаж нас 1,8, 2 жил хүрэх үү үгүй юү л байсан энэ 35 жилийн хугацаанд. Өмнөх Засгийн газар маань хамгийн тогтвортой ажилласан. Би Оюун-Эрдэнэ Ерөнхий сайдтайгаа хамт болон бусад сайд нарынхаа хамтаар энэ өнгөрсөн 4 жил дээр маш хүнд үеүдийг хамт өнгөрүүлсэн. Маш хүнд үеүдийг шүү. Ковидын үе, геополитикийн ямар хүнд үе байлаа, гадаад нөхцөл байдал дайн тулаан. Мөн манай гол түүхий эдүүдийн үнэ гадна талдаа их боломжтой сайхан байсан тэр үеийг ч бид хүрч чадсан.

Улсын Их Хурлын сонгуулийн ялалтыг ч бид хамтдаа байгуулж чадсан. Тэр бүгдийг Улсын Их Хурал дээрээс Засгийн газар нь ямар их дэмжлэгтэй байхад Засгийн газар ямар тогтвортой үйл ажиллагаа явуулж энэ бүгдийг давдаг юм бэ гэдгийг энэ түүх харуулж байгаа. Би энийг л сануулах гэсэн юм. Тэрнээс биш Засгийн газрыг огцруулахаар бичсэн шалтгууд шүү, шалтгаан биш, шалтгууд. Өөр шалтгаан байх шиг байгаа юм. Тэр шалтгааныг нь та бүхэн бүгдээрээ дор бүрнээ эргэцүүлнэ биз. Тэр шалтгуудыг тайлбарлаж болно, тал талаас нь тайлбарлаж болно. Нөгөө лам олдохгүй бол буцахдаа зална гэдэг шиг.

Сайнзориг гишүүн залуу хүн, би залуу сайн хуульч, ирээдүйтэй гэж боддог залуу маань харин цаашдаа буруу ирээдүй рүү явчих вий. Би энэ дүүгийнхээ төлөө их хайрлаж байгаа, гамнаж байгаа шүү Сайнзориг гишүүнээ. Би олон зүйл хэлэхгүй байна. Энэ бүхнийг л сануулах гэсэн юм.

Ц.Сандаг-Очир: Чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 9.7-д гишүүн хуралдаанд байр сууриа илэрхийлж үг хэлэх хугацаа 4 минутаас илүүгүй байна гэж байгаа. Тэгэхээр гишүүдийн үг 4 минут хүртэл хугацаанд байгаа гэдгийг хэлье. Дарааллын дагуу Ж.Бат-Эрдэнэ гишүүн үгээ хэлнэ. Хэлэхгүй юу? Бат-Эрдэнэ гишүүн нэрээ татлаа. Хэрлэн гишүүн үгээ хэлнэ.

Б.Хэрлэн: Тэгэхээр Пүрэвжавын Сайнзориг нарын гаргасан энэ саналыг би дэмжихгүй байгаа. Учир нь үндэслэл болчихоор юм алга. 1 дүгээрт, Улсын Их Хурал, Ерөнхийлөгчид танилцуулалгүй Баттөмөрийн Энхбаярыг Хууль зүй, дотоод хэргийн сайдаар томиллоо гэж олон нийтийн хэвлэл мэдээллээр мэдээллээ гэж байгаа юм. Энэ улс төрийн шийдвэрээ гаргасан, томиллоо гээд хэлчхэнгүүт энэ хүн очоод ажил албан тушаалаа аваад хийгээд явчихсан юм байхгүй л дээ. Процесс үргэлжилж байгаа, дуусаагүй байгаа. Харин Улсын Их Хурлынхаа хуулийн дагуу Улсын Их Хурал дээр танилцуулах, тангараг өргөх ажлыг нь шуурхайлах хэрэгтэй.

2 дахь нь Баттөмөрийн Энхбаярыг Хууль зүй, дотоод хэргийн сайд болгож байгаад бүрэн эрхэд нь хамаарахгүй, өөртөө ашигтай ажил, үүрэг хариуцуулах шинжтэй байна гэж үндэслэл бичсэн байгаа юм. Ингэж хардаж сэрдэх сэтгэлээр Ерөнхий сайдын бүрэн эрхэд халдаж, ажил үүргээс нь чөлөөлөх гэж болдог юм уу? Тоймтой үндэслэл нотолгоо байхгүй, барин тавин баримт байхгүй ингэж хөнгөн гоомой төр засгийг огцруулах асуудалд хандаж болдог юм уу? Ялангуяа төр засагтай холбоотой асуудал дээр бид нэлээн бодитой, ултай суурьтай хандах ёстой юм биш үү гэж би асуумаар байна.

3 дахь нь тэр Амнат-ийн татварын тухай асуудал байгаа. Амнат-ийн татварын тухай 55 дугаар тогтоолыг үндэслэсэн байгаа. Үгүй ээ, хоосон олон дэмий үгнээс илүүтэй бодитой үр дүн чинь үнэн зөвийг нь ялгаад өгч байгаа юм биш үү. Тэр биржээр борлуулж байгаа борлуулалтын дүн, татварын орлого өслөө, төсөвт орж ирж байгаа мөнгө нь нэмэгдэж байна гээд зөндөө ярьж байна шүү дээ. Энэ бол үндэслэл болохгүй гэж би бодож байгаа.

Одоо ингээд цонхоор харвал цаана чинь багш, эмч нар ажил хаяж байна, хүүхдүүд нь гэртээ эзгүй цоожтой байна. Цас ороод зам харгуй чинь хаагдчихсан байна, хийх ажил зөндөө байна бидэнд. Энэ цалин хөлснийхөө тогтолцоог хүнд ээлтэй болгож өөрчилье л дөө. Багш, эмч нарынхаа цалинг нэмэх 831 тэрбум төгрөгөө олох аргаа бодъё л доо. Өөр асуудал зөндөө их овоорч байна, энийгээ хиймээр байна.

Ер нь сүүлийн үед бид энэ хуулийг дээдлэх гэдэг зарчмыг бид нэг харилцан адилгүйгээр ойлгоод байх шиг байх юм. Төрийн байгууллага нь ч тэр, аж ахуйн нэгж байгууллага нь ч тэр, улс төрийн нам нь ч тэр хууль, дүрэм, журмын дагуу тэнд юу зөвшөөрөгдсөн юм тэрний дагуу бид ажиллах ёстой байна. Тэгтэл хуулиар хориглоогүй бол, хуульд хориглосон заалт байхгүй бол болно гэх жишээтэйгээр юманд хандаад байна. Эндээс бид тэр нөгөө дабль стандарт гэдгийг чинь үүсгээд байна. Эндээс бид овжин зальжин нь хожоод байдаг, үнэн, хуулийн дагуу явсангууд нь хожигддог ийм амьдралыг бид бий болгох гээд байна.

Энийг би ялангуяа энэ Байнгын хорооны энэ хуралдаантай холбогдуулж би хэлмээр байна. Улсын Их Хурлын тухай хууль, Дэгийн хуулийн тухай энэ хуралд бэлтгэх, энэ хуралтай холбоотой материалыг гишүүдэд хүргэх, олон нийтэд мэдээллийг нээлттэй, ил тод болгох ийм хуулийн зохицуулалтууд байсаар байтал хэсэг нэг хүмүүсийн хурал дээр материалыг тараагаач гэсэн саналыг нь хүлээж аваад л, болохгүй зүйл байхгүй болно гээд л ямар ч бэлтгэлгүй биднийг хуралд оруулж ирэхэд хүргэж байдаг. Тэгээд хууль тогтоож байгаа хүмүүс хуулийг өөрийнхөө дур зоргоор тайлбарлаж, өөртөө таатайгаар хэрэглэж ингэж яваад байвал энэ Монгол нийгэмд чинь хууль, дүрэм, журам байхгүй боллоо. Энийгээ ер нь цаашдаа татмаар байна. Хууль дээдлэх ёс гэдгийг нэг мөр ойлгож, зөв хэрэгжүүлмээр байна. Хуульд юу зөвшөөрсөн юм, хуулийн ямар зохицуулалт байгаа юм тэрний дагуу л ажиллаж, амьдардаг болмоор байна. Тэрнээс биш дур зоргоороо тайлбарладаг, хуулиар хориглоогүй бол болно гэж аливаа юмыг тайлбарладаг байдлаа энэнээс цааш татмаар байна гэж би хэлж байна. Тэгээд энэ бол саналыг би дэмжихгүй.

Ц.Сандаг-Очир: Хэрлэн гишүүн үгээ хэллээ. Сандагийн Бямбацогт гишүүн үгээ хэлнэ.

С.Бямбацогт: Гишүүдийнхээ өглөөний амгаланг айлтгая. Монгол Улсын Үндсэн хуулийн 23.1-д Улсын Их Хурлын гишүүн ард түмний элч бөгөөд нийт улсын эрх ашгийг эрхэмлэнэ гэж заасан байдаг, эрхэмлэн баримтална. Харамсалтай нь өнөөдөр энэ Үндсэн хуулийн энэ заалтаа бид санахаа больчихсон юм уу, Их Хурлын гишүүн болохоороо ааш аяг нь дийлдэхээ больчихсон, алхаа гишгээ нь өөрчлөгдчихсөн нэг л их том хүмүүс гэж өөрсдийгөө бодоод байх юм. Бид үүрэгтэй улсууд, нийт улс, иргэн, улсын эрх ашгийг эрхэмлэн баримтлах үүрэгтэй.

Гадаа цас орж байна, өвөл болж байна, малчид маань өвлийг яаж өнтэй давах вэ гэж бөөн асуудал болж байна. Иргэд маань түлээ түлшээ базааж байна. Засгийн газар цаг наргүй, өдөр, шөнөгүй л яаж улсаа гал алдуулахгүй байх вэ гэдэг дээр хичээгээд ажиллаж байна. Гэтэл бид энэ Төрийн ордонд 9 сарын 1-нд өргөн барьсан төсвөө 45 хоног хэлэлцдэггүй. Багш нарынхаа цалинг, эмч нарынхаа цалинг, ахмадуудынхаа тэтгэврийг нэмэх бололцоо боломж юу байна гэж ярьдаггүй хойш нь тавьчихдаг, гэмт хэрэгтэй тэмцье, энэ нүүрсний хулгай гэж яригдаж байгаа олон нийтийн жигшээд зэвүүцээд байгаа асуудлыг нэг тийш нь болгоё гэхээр ярьдаггүй нэг ийм л байдалтай болчихсон. Тэгсэн мөртөө нэг хүний, нэг бүлэглэлийн, нэг намын эрх ашгийг эрхэмлээд байгаа юм уу хаашаа юм. Нийт иргэн, улсын эрх ашиг яасан бэ, Үндсэн хуульд өргөсөн тангараг хаачсан бэ?

Одоо энэ төр улсаа бодъё л доо. Төрөөрөө тоглож боллоо шүү дээ, хангалттай шүү дээ. Айлын хүүхдүүд, жоохон хүүхдүүд айл гэр болоод чулуугаар тоглодог газар энэ биш. Энэ чинь төрт ёс, түүхэн уламжлал, төрийн хууль дээдлэх ёстой газар. Энийгээ бас нэг санадаг мэддэг, энийгээ бас нэг баримтлахыг хичээдэг баймаар байна шүү дээ. Айл гэр болж тоглож байгаа юм шиг тэгээд л Засгийн газраа огцруулна гээд дөнгөж 100-хан хонож байгаа Засгийн газраа. Яаж дэмжих вэ, яаж сайн ажиллуулах вэ, яаж улс орныхоо эрх ашгийг эрхэмлэх вэ, яаж төрийн хуулийг дээдлэх вэ гэж бодох ёстой байтал одоо болоо юм биш үү. Хууль ёс гэж байхгүй болчихсон. Бид тангараг өргөхдөө хуулийг чандлан сахина гэж тангараг өргөдөг.

Засгийн газрыг огцруулах асуудал байнга хууль зөрчиж байгаа Дэгийн хууль, Улсын Их Хурлын тухай хууль, Үндсэн хууль. Нэг алх, тамга барьчихаараа тэгээд алхаа гишгээ нь өөрчлөгдөөд, хуулийг өөрийнхөө тааллаар тайлбарладаг, үзэмжээр асуудлыг шийддэг, ингэж хүч түрдэг ийм байвал Монгол Улсад хууль байгаад хэрэгтэй юм уу, арай л хэтрээд байгаа юм биш үү? Асуудлыг чинь ярилцаад, ойлголцоод, эвлээд тал талаас ярьж болно шүү дээ. Тийм юм байхгүй, тэгээд ерөөсөө л олонхоороо хүч түрнэ гэдэг асуудлаар тэгээд л. Бүлгээ хуралдуулаад, асуудлаа шийдэхээр Бүлэг нь хуралддаггүй 2 долоо хоног, асуудлаа ярилцъя, шийдье гэхээр шийддэггүй. Олонхоороо ойлголцоод, асуудлаа шийдэж болдог юм Бат-Эрдэнэ дарга. Тэгээд ийм байдалдаа одоо цэг тавьцгаая, гадаа гал алдах гээд байна шүү нөхөд өө, төр улсаа бодъё.

Ц.Сандаг-Очир: Сандагийн Бямбацогт гишүүн үгээ хэллээ. Чинбатын Номин гишүүн нэрээ татлаа. Энхцэцэг гишүүн үгээ хэлье.

М.Энхцэцэг: Сайн байцгаана уу, та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Ёстой үнэхээр хэлэх үг олдохгүй байна. Уул нь зүгээр л нэг намын даргын сонгууль болсон, намын бага хурлын 400 гаруй гишүүд нь бүхэл бүтэн 22 цаг сууж байж намынхаа даргыг сонгосон. Гэтэл 100 хувь гараа ярс хийтэл өргөж намайг дарга болгосонгүй гээд нэр дэвшигч маань өнөөдөр уурлаад, төр засгийн ажлыг яаж гацааж болдгийг, төрийн түшээдээс нь авхуулаад түмэн олныг яаж айлгаж ичээж, уурлуулж бухимдуулж болдгийг жинхэнэ утгаар нь харуулсан ийм өдрүүд байлаа гэж хэлмээр байна. Үнэхээр сонгуулиас хойш surprise-гүй нэг ч өдөр байсангүй. Хууль биш, хүн засаглах нь ямар аюултай болохыг, парламентын засаглал ямар чухал болохыг, ардчилал үнэхээр ямар чухал болохыг ойлгосон өдрүүд байлаа гэж харж байна.

Ямар азаар бид 126 гишүүнтэй Улсын Их Хуралтай болсон юм, ямар азаар бид барьцаалагдах юмгүй бардам, нэр цэвэр олон гишүүнтэй болсон юм гэж бодогдуулсан өдрүүд байлаа. Хууль хүчний байгууллагыг яаж увайгүй улс төрийн зорилгоор ашиглаж болдгийг харуулсан өдрүүд байлаа. Яаж гүтгэж доромжилж, харлуулж болдог гэдгийг харуулсан өдрүүд байлаа. Хэдхэн хүн энхийн цагаан тагтаа, бусад нь бүгд нүүрсний хулгайчид болж гүтгүүлээ. Тэгээд бүр бод доо, ямар ч баримт нотолгоогүй, зүгээр л нэг гаднын сайтын ганц мэдээн дээр үндэслээд, бүхэл бүтэн төрийн 3 өндөрлөгийнхөө нэгийг гүтгээд, гэмт хэрэгтэн мэтээр олон нийтийн сүлжээнд яллаад, ажлыг нь хийлгэхгүй айлгаж сүрдүүлээд, ажлаа өг, ажлаа өг гээд, Засгийн газрын сайдууд Улсын Их Хурлын гишүүдийг турхираад ашиглаад зогсож байгааг харлаа шүү дээ хэдүүлээ.

Тэр парламентын бүрэн эрхэд халдаж байгааг бол жинхэнэ утгаар нь үзүүлээ. Бүхэл бүтэн парламентын нэг бүрдэл болсон бүлгийг нь Бүлгийн даргын хурлыг Бүлгийн даргын зөвшөөрөлгүйгээр хуралдуулаад, бүр тас 2 хуваагаад, өдөр болгон нэг дарга сонгоод тоглоод зогсож байхыг хэдүүлээ харлаа шүү дээ. Ийм байж болохгүй шүү дээ. Тэгээд хүнийг гүтгэж харлуулахдаа ашигласан этгээдээ өнөөдөр сайдын суудлаар шагнаад зогсож байхыг харлаа шүү дээ. Ийм л өдрүүд боллоо гэж би дүгнэж хэлмээр байна. Үнэхээр бүр галзуурлын байдалтай, эмх замбараагүй, хууль дүрмээ мөрдөхгүй ийм л өдрүүд өнөөдөр 9 сарын 27-ноос хойш 3 долоо хоног үргэлжиллээ. Энэ бол арай л дэндэж байна. Энгийг бид зогсоох ёстой. Үнэхээр хууль гэж байдаг бол төрийн тогтворгүй байдал бий болгосны төлөө, парламентын эрхэд халдсаны төлөө, төрийн түшээдээс нь авхуулаад түмэн олныг айлгаж ичээж, бухимдуулсныхаа төлөө хариуцлага хүлээх ёстой гэж үзэж байгаа. Үнэхээр харамсалтай, ёстой хэлэх үг олдохгүй байна л гэж хэлье дээ.

Ц.Сандаг-Очир: Энхцэцэг гишүүн үгээ хэллээ. Оюун-Эрдэнэ гишүүн нэрээ татлаа. Мандхай гишүүн үгээ хэлье.

М.Мандхай: Яах вэ дээ ер нь нийт ард иргэд угаасаа ч иргэд бичиж байна, ярьж байна. Зүгээр л энэ хуулийг гууль болгодог юм байна, хууль бол эрх мэдэлтэй хүмүүст хэрэгждэггүй юм байна. Жагсаалтаар орсон шинэ гишүүдийг элдвээр хэлж доромжилж чаддаг юм байна, бид троллуудаар элдвээрээ хэлүүлж дууслаа. Энэ улс орныхоо төлөө, салбарыгаа төлөөлж үг хэлдэг гишүүдийг элдвээр хэлээд дууслаа. Энэ юу вэ гэхлээр өнөөдөр бид парламентаа барьцаалж байгаад Үндсэн хуулиа зөрчөөд, Засгийнх нь аппарат нь парламентынхаа аппарат дээр гарч байгаад нухчин дардаг юм байна. Өнөөдөр бид дарангуйлал тогтлоо гэдгийг бүүр бодитой хэлж болно.

Хамгийн их үг хэлж дуугарч гарч ирж байгаа хүмүүсийгээ ард иргэд бол угаасаа харж байгаа. Яг бодитой байдал Засгийн газар яагаад унах ёстой юм, яагаад энэ Ерөнхий сайд ажлаа хийж чадахгүй юм бэ, үгүй ээ энэ бодитой шүү дээ. Өнөөдөр багш нар 2 багшийн хөдөлмөрөөр 1,4 сая төгрөгийн цалинтай ажиллаж байгаа. Өнөөдөр Засгийн газрын энэ гишүүдийн хүүхдүүд нь хувийн сургуульд явдаг. Энгийн иргэд ерөнхий боловсролын сургуульд хүүхдүүдээ зөөгөөд явж байгаа. 1,4 сая төгрөгийн цалинтай бүтэн 12-оос 14 цагийн илүү цагаар ажилладаг ийм нөхцөл байдалд цалингаа нэмүүлье гэж байхад, ТҮК-ийн ажилчдаасаа доогуур цалинтай л ажиллаж байна шүү дээ. Яагаад тэр түвшинд очиж болохгүй юм бэ 3,5 сая? Нэмж чадахгүй гэж байгаа юм. 2028 он хүртэл шаталж нэмнэ гэнэ. Үгүй ээ боль л доо та нар.

Та нар Амнат-ийнхаа мөнгө, Сайнзориг гишүүн яриад байгаа шүү дээ. Олон улсын ийм өндөр өртгөөр хэмжигдэх нүүрснийхээ экспортын бүтээгдэхүүнийг дотоодын доогуур үнэлгээтэй 25 хувийнхаа үнэлгээнд дүйцүүлж байгаад, хууль зөрчиж өөрсдөө үнэлгээг нь унагааж, хувийн хэвшилд зөвхөн борлуулалтын ашиг болгож оруулаад, улсад оногдох татварыг нь буулгаж өгчхөөд, бид яг ингээд харвал маш олон хэмжээгээр орлогоо хэмнэх, орлогоо биш ээ, орлогоо нэмэгдүүлэх, зардлаа хэмнэх ийм боломж байхад хулгай хийх боломжийг нь өөрсдөө бий болгож өгчхөөд, эмч, багш, тэтгэврийн цалинг нэмж чадахгүй гээд сууж байхаасаа ичих хэрэгтэй шүү дээ. Хөдөө орон нутагт өнөөдөр хар даа, та нар нэг зүйлийг сайн ойлгох хэрэгтэй. Ургац хураалт, малын тэжээл, хүнсний бид хангамж хүрэхгүй байдалд оччихсон байгаа шүү. Өнөөдөр Төв аймгийн Цээл сумын иргэн бичиж байна лээ. Бензин олдохгүй байна, бид ядаж 5 литр бензиний нөөцтэй байдаг, одоо бүр бензинээ авч чадахгүй бидний амьдрал хүндэрлээ гээд бичиж байгаа шүү дээ. Үгүй ээ яг бодит байдал чинь энэ шүү дээ.

Сошиал дээр зүгээр л хөөсөрсөн нэг худал, үнэн мэдээлэл яваад байгаа. Бид энэ өвөл маш хэцүү байдалд орох гээд байна, хүнсний хангамжаа авч чадахгүй байгаад байна, энэ малчид чинь малын тэжээлээ өрөхгүй. Яаж ичихгүй сандал суудлын хэрүүл хийж чадаж байна, ичиж үхмээр юм. Тэгээд ингээд энд байгаа зарим гишүүд нь ингээд хууль, дүрэм, журмаа мэдэхгүй, зүгээр улс төржөөд суугаад байх юм, ичээч та нар. Хэлэх үг ч алга байна яг үнэнээ хэлэхэд. Энэ Засгийн газар бол угаасаа чадамжгүй байгааг би ярьж, ярьсаар л ирсэн. Чадахгүй, сандал суудлын хэрүүл гарч байгаа ийм нөхдүүдийг одоо яаралтай татаж буулгаад, үндсэн ажилдаа орж, төрийнхөө ажлыг хэвийн явуулмаар байна гэдгээ хэлмээр байна.

Ц.Сандаг-Очир: Мандхай гишүүн үгээ хэллээ. Дамбын Батлут гишүүн үгээ хэлнэ.

Д.Батлут: Гишүүдийнхээ өглөөний мэндийг хүргэе. Сүүлийн хэдэн хоног ч бид булаагаа дэлгэж байна даа. Нэг нь төрийн мөнгөнөөс хумсалж аваад л, нөгөөгөө гаднын хэвлэлд өгч бичүүлдэг байх ч шиг. Өнгөн дээрээ нэг тийм шударга дүртэй хүмүүс. Яг хачир дээрээ юу ч байхгүй. Шударга биш дандаа үйлдэл хийж яваа. Тэгээд Оюу толгойн гэрээг сайжруулъя, Оюу толгойгоос Монголын ард түмэн ашиг шим хүртдэг байя гээд л дарцагласан нөхдүүд байгаа. Гэтэл хэдэн арван саяар нь Оюун толгойгоос мөнгө аваад Монголоо сурталчлах нэртэй гадныханд өгөөд мөнгө угаачихсан баримтууд нь гараад ирчихлээ. Энийг чинь Оюу толгойгоос авлига авсан гэж хэлэхгүй юу гэж хэлэх юм. Тэгээд студиэ хэдэн сая төгрөгөөр, доллароор тоноглоод хаячихсан, хөрөнгө оруулалт хийчихсэн. Үүнийхээ дараа яаж тэр Оюу толгойн төслийг сайжруулъя, энэ ард түмэндээ өгөөжтэй болгоё гэж яаж хэлж ярьж чадах юм бэ? Арай дэндэж байгаа.

7 тэрбум төгрөг Эрдэнэс Оюу толгойгоос аваад тоног, төхөөрөмж аваад студиэ шинэчлээд янзалчихсан ч байх шиг. Английн хөл бөмбөгийн шигшээ багийн хувцас хэрэглэлийг авч өгнө гээд 23 тэрбум төгрөг гаргаад хаячихсан ч байх шиг. Ямар баян юм бэ. Монголын хөл бөмбөгийн баг нь ямар байгаа юм бэ мэдэж байгаа юу та нар? Ийм, ийм арчаагүй үйлдлүүд хийж байгаа нь бүр үнэхээр гутамшиг байна.

Тэгээд одоо Их Хурал, энэ Төрийн байгуулалтын байнгын хороо нь ч гэсэн хурлаа хийж чадахаа байчихсан, Дэгийн хуулиа зөрччихсэн, өөрсдийн тааллаар асуудлаа шийддэг болчихсон. Алх байгаа болохоор цохиод цохиод л явчхаж байх шиг байгаа юм л даа. Иймэрхүү зүйлүүд хийж явахаа болимоор байгаа юм.

Хүний мэдэх эрхийг хязгаарлахгүй харин Улсын Их Хурлаар сонсгол хийж явдаг нь харин авууштай болсон юм байна. Хүн мэдэх эрхтэй байгаа, хүмүүс мэдэх хэрэгтэй байгаа. Ингэж байж бид бүхэн цаашлаад олон сайн мэдээллүүдийг олж авч явна гэж би бодож байгаа юм. Өнөөдөр манай Улсын Их Хурлын 67 гишүүн Улсын Их Хурлын даргыг нүүрсний асуудалд холбогдоод байна та шалгуул гэдэг байдлаар шаардлага хүргүүлсэн. Тэгсэн чинь одоо нөгөөдөх нь юу болж хувирсан гэж бодож байна, бидэнд нэг гишүүдэд нэг өнгөтөөр хэвлэсэн юм өгсөн байна л даа. Тэгээд өнгөтөөр хэвлэсэн юман дотор нь ингээд үзээд байнгуут зүгээр нэг статистикаас нэг лавлагаа авчихсан. Үгүй ээ мэдээж тэр дата дээр нь байгаа мэдээллийг л өгнө шүү дээ. Мэдээж өөрийнхөө нэрийг оруулсан тэр мэдээлэл юу, яаж тэнд нь байх юм бэ?

Админерал гэж компани өөрөө Бортээгийн уурхайг 100 хувь зарж борлуулахаар гэрээ хийчихсэн байгаа шүү. Нэг хүрз нүүрс аваагүй гээд байгаа юм. Одоо 100 хувь зарж борлуулахаар Админерал компани гэрээ хийгдсэн байгаа шүү. Дээрээс нь Тавантолгой дээр 35 га газар авчихсан, Админерал компанийн эцсийн өмчлөгч нь Их Хурлын даргын туслахтай, гэр бүлийнхэнтэй нэгдмэл сонирхолтой нэг компанийн компани эзэмшиж байгаа. Энэ Админерал компанийн гүйцэтгэх захирал нь Улсын Их Хурлын даргын ахынх нь хүүхэдтэй нэг компани хамтарч эзэмшиж байгаа. Энийг чинь хамаарал гэхгүй яах юм. Энэ дотор олон асуудлууд гарна, тодорхой болно цаг хугацааны хувьд. Тэгээд тэр тендер зарлахдаа 3 удаа зарлаад, тухайн компанид нь Админерал компанид нь ингээд хөнгөлөлттэй нөхцөлөөр бүх зүйлүүдийг нь хангаж өгөөд шалгаруулчихдаг гэнэ. Яах вэ та бүхэн энэ Байнгын хороон дээр олонх болж болно. Их Хурлын танхимд ард түмэн олонх.../минут дуусав/

Ц.Сандаг-Очир: Батлут гишүүн үгээ хэллээ. Хэн нэгнийг гүтгэж болохгүй, нотлох баримттай ярина шүү л гээд байгаа шүү Батлут гишүүнээ. Ерөнхий сайд нь барууны сайтад гарсан хэвлэлээр хүн гүтгэж байгаа юм чинь сайдууд нь ч арга ч үгүй байх л даа. Гол нь тэгээд нотлох баримттай юм ярина шүү. Хэн нэгнийг нотлогдоогүй баримтаар ингээд өнөөдрийг хүртэл гүтгэж явж ирж байгаа шүү. Энийг чинь олон түмэн харж байгаа шүү. Энхбатын Болормаа гишүүн үгээ хэлье.

Э.Болормаа: Сүүлийн сар орчим ерөөсөө бүх юм сайхан ус, тосоороо ялгарч байх шиг байна. Сүүлийн 10, 20 жил энэ ордонд, энэ танхимд шийдвэр гаргалцаж ирсэн өнөөдрийн нөхцөл байдлыг бий болгосон хүмүүс ардын жүжигчин шиг л энэ дотор сайхан гоё юм ярьж байна. Тэгээд бид яг л ил тод харж байна л даа ер нь камер дээр яаж гишүүдийг барагтайхан байгаарай, хэмжээндээ байгаарай, барьж авч зодож цохих нь холгүй ийм л нөхцөл байдалтай туулж байгаа. Энэ бол ил болж байгаа юм нь. Ерөнхий сайдын даалгавраар хэвлэлийн хурлууд яаж болж байгааг, хэдэн ахмад зүтгэлтнүүдийг дуудаж ирээд л ийм юм хэл, тийм юм хэл, энэ нэг хэдэн гишүүдийг нэг солонгосын драмын жүжигчид шиг ингээд л байнга эвлүүлэг хийгээд л, Засгийн газрын хэвлэл нь ерөөсөө л нэг парламентыг гүтгэх ийм ажлыг хийж байгаа.

Маш том засаглалын доголдол руу бид орж байгаа юм. Яагаад энэ Засгийн газрыг дэмжихгүй байгаа миний үндсэн шалтгаан бол хэдий Ерөнхий сайд өөрийн бүрэн эрхийн хүрээнд хэнийг ч сайдаараа томилж болно. Гэхдээ энэ Үндсэн хуулийн үг, цэг, таслал болгон учиртай. Яагаад Ерөнхий сайд Ерөнхийлөгчид, мөн Улсын Их Хуралд танилцуулах ёстой юм. Ерөнхий сайдыг огцруулах асуудал хүртэл сэтгэлийн хөөрлөөр бус 3 хоногийн дараанаас хэлэлцэж эхэлнэ, дараагаас, энэ хооронд хэлэлцэж, ярилцах хугацаа өгөхөөс авхуулаад энэ улс орны байдал хэцүүдэх вий гээд 10 хоногийн дотор хэлэлцэж дуусна гэх мэтчилэн энэ болгон утга учиртай юм. Парламентыг үл хүндэтгэж байгаа биш, энэ өөрөө Үндсэн хуулийг уландаа гишгэж, засаглалын доройтол руу аваачиж байгаа.

Бусад улсуудын түүх би одоо нэр зааж яах вэ. Гэхдээ түүхэнд дарангуйлал руу орох аягүй амархан байдаг. Маш тод жишээ бол дандаа л ер нь улс төрийн өрсөлдөгчөө намнадаг хууль шүүхийн байгууллагаар. Тэгэхээр хэдий өөрийн бүрэн эрх ч байсан ямар сэдлээр, ямар зорилгоор Хууль зүй, дотоод хэргийн сайдыг томилох гэж байгаа вэ гэдгээ маш тод ил зарлана гэдэг өөрөө Монгол Улс засаглалын хямрал руу орж, дарангуйлал руу ойртох гээд байна гэдэг утгаар би залуу хүний хувьд энэ Засгийн газрыг дэмжихгүй байгаа. Бусад олон асуудал байгаа. Ажил нь яагаад явахгүй байгаа энэ тэр гээд олон гишүүд ярьж байгаа. Гэхдээ хамгийн чухал асуудал нь энэ Засгийн газрын ийм байдлаар олон нийтэд бид парламентаа яаж барьцаалж байгааг нь бүгдээрээ харж байна, гүтгэж, араас нь яллах гэж дайрч байгаа байдал бол Монгол Улсын ардчиллыг доройтуулах гэж байна гэж үзэж байна.

Тийм учраас энэ Засгийн газрыг дэмжихгүй байгаа. Олон нийт ил тод энэ бүх яриануудыг харж байгаа. Ус, тосоороо ялгарч байгаа. 10, 20, 30 жил бараг энэ танхимд сууж байгаа хүмүүс өнөөдөр хаана, ямар эрх ашгийн төлөө явж байна. Сүүлийн жил орж ирээд энэ болохгүй бүхнийг ухаараад, засаж залруулах гэж явж байгаа хүмүүсийг ахын дүү нар хэмжээндээ байгаарай гэдэг ийм л зүйлүүд явж байгааг та бүхэн харж байгаа. Тэгэхээр залуучууддаа уриалж хэлэхэд, ялангуяа би энэ нам хамаарахгүй, энэ парламентын олонх нь шинэ гишүүд байгаа. Ардчилсан

намын гишүүд, бусад намынхаа гишүүддээ ардчиллыг бид хамгаалахгүй бол өөр хүн хамгаалж чадахгүй шүү. Энэ Засаг унахгүй бол ардчилал доройтох гээд байна шүү гэдгийг олон нийт анхааралтай ажиглаасай гэж хүсэж байна.

Ц.Сандаг-Очир: Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулж гишүүд асуулт асууж, хариулт авч дууссан, үг хэлж дууслаа. Одоо хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулж санал хураалт явуулна. Гишүүд санал хураалтдаа бэлдээрэй. Ирцдээ орсон гишүүдийг дуудаарай. Санал хураалтад. Ариунзаяа гишүүн, Баярбаатар гишүүн, Болормаа гишүүн, Идэрбат гишүүн, Лодойсамбуу гишүүн, Номин гишүүн, Сандаг-Очир гишүүн, Хэрлэн гишүүн гэсэн гишүүд санал хураалтдаа бэлтгэгдсэн байна. Амарбаясгалан гишүүн, Бадамсүрэн гишүүн, Бат-Эрдэнэ гишүүн, Бямбацогт гишүүн, Гантөмөр гишүүн, Даваасүрэн гишүүн, Зулпхар гишүүн, Мөнхбаатар гишүүн, Номтойбаяр гишүүн, Одбаяр гишүүн, Оюун-Эрдэнэ гишүүн, Саранчулуун гишүүн, Туваан гишүүн, Уянгахишиг гишүүн нар санал хураалтдаа бэлдье. Хуруугаа уншуулаарай. Гишүүд санал хураалтдаа бэлдээрэй, ороорой. Бямбацогт гишүүнээ. Төхөөрөмжөө идэвхжүүлээгүй байна. Энэ дээр, сая би уншсан гишүүдийнх төхөөрөмж нь идэвхэжсэн гишүүдийнх, сүүлд уншсан гишүүдийнх төхөөрөмж нь, Гантөмөр гишүүн идэвхжээгүй байна.

14 гишүүн идэвхэжсэн байна, тийм. Санал хураалт. 32-оос 22 гишүүн ирсэн, 68,8 хувийн ирцтэй байна. Тэгээд яах юм бэ одоо санал хураалтад, дууд, дуудаж байгаа байх манайхан. Санал хураалт. Бүгд зурагтаараа үзэж байгаа наадуул чинь, дуудаарай. Туваан гишүүн идэвхжээгүй байна. Туваан гишүүн түрүүн орж ирж байсан даа. Номтойбаяр гишүүн ер нь ирээгүй байна тийм ээ, ирсэн юм уу? Ирчихсэн байна. Номтойбаяр гишүүн ирцдээ ч орчихсон байна, саналаа ч идэвхжүүлчихсэн байна. Санал чинь идэвхжээгүй байна Номтойбаяр гишүүнээ, хуруугаа, санал хураалтдаа бэлдээрэй. Гишүүн. Одоо санал хураах гэж байна, санал хураалтдаа бэлдээрэй гэж хуруугаа уншуулаарай л гэсэн. Санал хураалт. Таных идэвхжээгүй л байна, ирж байна? Та эсвэл наад талын нэг юун дээр суучих юм уу солиод. Санал хураалт.

Монгол Улсын Ерөнхий сайд Гомбожавын Занданшатарыг огцруулах саналыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураана. Санал хураалтад 22 гишүүн оролцож, 3 гишүүн зөвшөөрч, 13,6 хувиар санал дэмжигдсэнгүй. Санал, дүгнэлтийг танилцуулах, дэмжигдсэнгүй учраас санал, дүгнэлтийг танилцуулах, Байнгын хорооны санал, дүгнэлтийг миний бие өөрөө танилцуулна.

10.10 цаг

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан хаасныг мэдэгдье.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА